

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДОТООД АУДИТЫН  
2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

2023 оны 07 дугаар сарын 04

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын дэргэдэх Дотоод аудитын хорооны 2017 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын журам”, Гадаадын иргэн, харьяатын газрын Дотоод аудитын 2023 оны төлөвлөгөөг үндэслэн дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Төсөв, санхүүгийн чиглэлээр:

Байгууллагын дотоод аудитын 2023 оны төлөвлөгөөний дагуу төсөв, санхүү болон үйл ажиллагааны чиглэлээр 2, нийцлийн чиглэлээр 2, нийт 4 удаагийн төлөвлөгөөт аудитын шалгалтыг хийж, гүйцэтгэлээ.

Хяналт шалгалтыг төрлөөр нь ангилвал:

№	Хяналт, шалгалтын төрөл	Хамрагдсан байгууллагын нэр	Хяналт шалгалтын тоо	Тайлбар
1	Санхүүгийн болон үйл ажиллагааны чиглэлээр аудит	Дорноговь аймаг дахь газар	1 удаа	Төлөвлөгөөт
2		Баруун бүс дэх газар	1 удаа	Төлөвлөгөөт
3	Нийцлийн аудит /Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд/	Төв болон орон нутаг дахь газрууд	2 удаа	Төлөвлөгөөт

а) Байгууллагын даргын 2023 оны 01-02/26 дугаар удирдамжийн дагуу Дорноговь аймаг дахь газрын 2022 он, 2023 оны нэгдүгээр улирлын төсөв, санхүүгийн тайланд дотоод аудитын шалгалтыг хийж гүйцэтгэн, 05 дугаар сард 01/69 дугаар илтгэх хуудсаар шалгалтын үр дүнг байгууллагын даргад танилцуулав.

б) Байгууллагын даргын 2023 оны 01-02/27 дугаар удирдамжийн дагуу Баруун бүс дэх газрын 2022 он, 2023 оны нэгдүгээр улирлын төсөв, санхүүгийн тайланд дотоод аудитын шалгалтыг хийж гүйцэтгэн, 05 дугаар сард 01/77 дугаар илтгэх хуудсаар шалгалтын үр дүнг байгууллагын даргад танилцуулсан.

Хоёр. Нийцлийн аудитын чиглэлээр:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор төв болон орон нутаг дахь нэгжүүдийн цахим хуудсан дахь хуулийн хэрэгжилт болон түүнийг сайжруулах, хуулийн хугацаанд мэдээ, тайланг үнэн зөв, иж бүрэн байршуулж хэвшүүлэх талаар байгууллагын даргын 2023 оны 01-09/01, 01-09/02 дугаартай 2 удаагийн удирдамжийн дагуу 2022 оны IV, 2023 оны I улирлын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудитын шалгалтыг хийж гүйцэтгэн, 01-09/01, 01-09/05 дугаар илтгэх хуудсаар байгууллагын даргад танилцуулан тухай бүр холбогдох байгууллагад хүргүүлэн мэдээллээр хангаж ажиллалаа.

Дотоод аудитын шалгалтын үр дүнг Санхүүгийн хэлтэс болон орон нутаг дахь нэгжид 04 дүгээр сарын 18-ны өдрийн 09/06 дугаар дотоод албан бичгээр аудитын зөвлөмжийн хамт хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Гурав. Бусад асуудлаар:

Байгууллагын дотоод аудитын чиглэлээр 2022 онд гүйцэтгэсэн ажлын тайлан, 2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, Үндэсний аудитын газрын зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 01/2126 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Байгууллагын 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайланд үндэслэн байгууллагын даргаар 12 дугаар сарын 28-ны өдөр 4 чиглэлээр 11 арга хэмжээний эрсдэлийн “2023 онд эрсдэлийг сааруулах үйл ажиллагаа буюу хариу арга хэмжээний төлөвлөгөө”-г батлуулан, 04 дүгээр сарын 14-ний өдрийн 02/595 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Байгууллагын 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайланг гаргаж 01/2087 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд, 2023 оны I улирлын эрсдэлийн тайланг 05 дугаар сард [tsevelmaa@mojha.gov.mn](mailto:tsevelmaa@mojha.gov.mn) цахим хаягаар хүргүүлж тайлагналаа. Түүнчлэн Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээ систем ([mojha.unelgee.gov.mn](http://mojha.unelgee.gov.mn))-д 2022 оны 12 дугаар сарын 02, 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр эрсдэлийг үнэлэн, тайлагнаж, баталгаажуулсан.

Байгууллагын захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй Хууль зүй, дотоод хэргийн сайдын 5, байгууллагын даргын баталсан 4 шийдвэрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, байгууллагын даргад танилцуулан үнэлгээг, саналын хамт 04 дүгээр сарын 24-ний өдрийн 01/688 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж тайлагналаа.

Байгууллагын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн 2022 оны жилийн эцсийн тооллогын А/222 дугаар тушаал, 2023 оны хагас жилийн тооллогын А/186 дугаар “Эд хөрөнгийн тооллого зохион байгуулах тухай” тушаалын дагуу ажлын хэсэгт аудит хариуцсан мэргэжилтэн ажилласан.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ  
АУДИТЫН ХЭЛТЭС